



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2019 оны 08 сарын 27 өдөр

Дугаар А/359

Улаанбаатар хот

Монгол Улсын Их Сургуульд Технологийн
коллеж төгсөгчийг суралцуулах
түр журам батлах тухай

Дээд боловсролын тухай хуулийн 4.5 дэх заалт, БСШУС-ын сайдын 2018 оны А/194 дүгээр тушаал, МУИС-ийн дүрмийн 4.3.8.4 дэх заалт, МУИС-ийн Захиргааны зөвлөлийн 2019 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. “Монгол Улсын Их Сургуульд технологийн коллеж төгсөгчийг суралцуулах түр журам”-ыг хавсралтаар батлан мөрдсүгэй.
2. Журам батлагдсантай холбогдуулан элсэлтийн бодлого, журам сурталчлах, таниулах ажлыг зохион байгуулахыг Элсэлт бүртгэлийн хэлтэс /М.Итгэл/, Мэдээллийн технологийн газар /А.Баатарбилэг/ нарт даалгасугай.
3. Оюутан элсүүлэх ажлыг энэхүү журмын дагуу зохион байгуулах, үр дүнд нь хяналт тавьж ажиллахыг Сургалт, оюутан хариуцсан дэд захирал /Б.Очирхуяг/, Элсэлт бүртгэлийн хэлтсийн дарга хэлтсийн дарга /М.Итгэл/, Хөтөлбөр, чанарын баталгаажуулалтын хэлтсийн дарга /Н.Пүрэвцогт/ нарт үүрэг болгосугай.

ЗАХИРЛЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Я.ТӨМӨРБААТАР

Захирлын 2019 оны 08 дугаар
сарын 07-ны өдрийн 07 дугаар
тушаалын хавсралт



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬД ТЕХНОЛОГИЙН КОЛЛЕЖ ТӨГСӨГЧИЙГ СУРАЛЦУУЛАХ ТҮР ЖУРАМ

НЭГ.Ерөнхий зүйл

1.1. Монгол улсад бүртгэлтэй эсвэл түүнтэй адилтгах гадаадын ижил түвшний Технологийн коллеж төгссөн, дээд сургуулийн дипломын (С) зэрэг бүхий суралцагчийг Монгол Улсын Их Сургуульд (цаашид "МУИС" гэнэ)-д элсэн суралцах асуудлыг зохицуулахад энэхүү журмыг (цаашид "журам" гэнэ) мөрдөнө.

1.2. МУИС-ийн хөтөлбөрт элсэн суралцах хүсэлт гаргасан суралцагчийг "бүртгүүлэгч", элсэлтийн цахим бүртгэлийн системийг "бүртгэлийн нэгдсэн систем" (<http://burtgel.num.edu.mn>) гэнэ.

1.3. Элсэлтийн үйл ажиллагааг "Монгол улсын их сургуульд суралцагч шилжүүлэн суралцуулах журам"-д заагдсан "шилжилтийн комисс" зохион байгуулна.

1.4. Технологийн коллеж төгсөгчийг зөвхөн МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Байгалийн ухааны салбар сургууль болон Хэрэглээний шинжлэх ухаан, инженерчлэлийн сургуулийн ижил чиглэлийн хөтөлбөрүүдээс хяналтын тоонд багтаан шалгаруулан суралцуулна.

1.5. Элсэлт авах хөтөлбөр, хяналтын тоог бүрэлдэхүүн сургуулийн идэвхтэй суралцагчийн тоо, мэргэжлийн тэнхимийн санал зэрэгт үндэслэн тухай бүрд нь МУИС-ийн захирлын тушаалаар баталж зарлана.

1.6. Энэхүү журмаар зохицуулагдахгүй асуудлыг шилжилтийн комисс шийдвэрлэнэ.

ХОЁР. Бүртгүүлэгчид тавигдах шаардлага

2.1. Бүртгүүлэгч нь дараах ерөнхий шаардлагыг хангасан байна. Үүнд:

2.1.1. Сүүлийн 3 жилийн дотор технологийн коллеж төгссөн, дээд боловсролын дипломын (С) зэрэг эзэмшсэн байх.

2.1.2. Дипломын голч дүн 2,0-аас дээш байх.

2.2. Бүртгүүлэгчээс элсэлтийн ерөнхий шалгалт өгсөн байхыг шаардахгүй.

ГУРАВ. Элсэлтийн бүртгэл

3.1. Элсэлтийн бүртгэлийг хичээлийн жилд нэг удаа: намрын улиралд 07 дугаар сарын 01-ээс 08 дугаар сарын 15-ныг дуустал <http://burtgel.num.edu.mn> цахим хаягаар бүртгэх бөгөөд бүртгэнэ.

3.2. Бүртгүүлэгч нь бүртгэлийн нэгдсэн систем дэх анкетыг бөглөж, дараах бичиг баримтуудыг оруулна. Үүнд:

- Иргэний үнэмлэх эсвэл түүнтэй адилтгах баримт бичиг;

- Дипломын зэргийн боловсрол эзэмшсэнийг батлах баримт бичиг;
- Цээж зураг (Зургийн шаардлагыг бүртгэлийн нэгдсэн системээс үзнэ);

3.3. Тус журмын 3.2-д заасан бичиг баримт гадаад хэл дээр бол албан ёсны орчуулга хийлгэн, нотариатаар батлуулсан байна.

3.4. Хэрэв бүртгэл нь цахимаар явагдах боломжгүй тохиолдолд тус журмын 3.2-т заасан материалыг бүрдүүлж шилжилтийн комисст цаасаар хүлээлгэн өгнө.

3.5. Бүртгүүлэгч нь тус журмын 1.4-т заасан хөтөлбөрүүдээс хоёр хүртэл хөтөлбөрт элсэн суралцах хүсэлт гаргаж болох ба бүртгүүлсэн хөтөлбөрийн тоогоор бүртгэлийн хураамжийг цахимаар төлнө.

3.6. Бүртгэлийн хураамж нь МУИС-ийн ерөнхий суурийн 1 багц цагийн төлбөртэй тэнцүү байх ба МУИС-ийн төвлөрсөн санд төвлөрүүлж шалгалт зохион байгуулах ба бусад зардалд зарцуулна.

3.7. Бүртгүүлэгч нь бүртгэлийн системд бичиг баримтыг дутуу оруулсан эсвэл баримт бичиг нь шаардлага хангаагүй тохиолдолд элсэлтийн шалгалтад оруулахгүй байх үндэслэл болох ба энэ тохиолдолд бүртгэлийн хураамжийг буцааж олгоно.

3.8. Бүртгүүлэгч системд бүртгүүлсэн боловч МУИС-ийн үйл ажиллагаанаас үл хамааран элсэлтийн шалгалтыг өгөөгүй бол бүртгэлийн хураамжийг буцааж олгохгүй.

ДӨРӨВ. Элсэлтийн шалгалт

4.1. Бүртгүүлэгч нь элсэхийг хүссэн хөтөлбөрийн шаардлагын дагуу шалгалт өгөх ба шалгалт нь мэргэжлийн суурь мэдлэгийн үндсэн шалгалт ба нэмэлт (аман ярилцлага, эссе бичлэг гэх мэт) шалгалтаас бүрдэнэ. Энэхүү хоёр шалгалтын дүнг 60:40 хэмжээтэйгээр хувилж шалгалтын нийт оноог тооцно.

4.2. Шалгалт авах хугацаа, байр болон шалгалттай холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг бүртгэл хаагдахаас долоо хоногийн өмнө <http://burtgel.num.edu.mn> цахим хаягт байршуулна.

4.3. Шалгалт дууссаны дараа шилжилтийн комисс шалгалтын дүнг гарган бүртгэлийн нэгдсэн системд элсэлт хариуцсан мэргэжилтэн оруулж зарлана.

4.4. Шалгалтанд авбал зохих нийт онооны 60-аас доошгүй хувийг авсан шалгуулагчдыг оноогоор нь жагсааж, онооны дарааллаар хяналтын тоонд багтаан элсүүлнэ.

4.5. Оноо тэнцсэн тохиолдолд өмнө суралцсан хугацааны голч дүнг харгалзана.


4.6. Бүртгүүлэгчийн голч дүн 3.6 ба түүнээс дээш бол шалгалтгүйгээр шууд элсүүлэн суралцах эрх олгоно.

ТАВ. Элсэн суралцах эрх олгох

5.1. Бүртгүүлэгч хоёр хүртэлх хөтөлбөрт элсэн суралцахаар бүртгүүлж болох боловч зөвхөн нэг хөтөлбөрт элсэн суралцах эрх авна.

5.2. Хяналтын тоонд багтсан бүртгүүлэгч нь тус журмын 3.2-т заасан материалыг эх хувиар нь дүн гарснаас хойш ажлын 5 хоногт багтаан бүрэлдэхүүн сургууль дээр өөрийн биеэр ирж бүртгүүлж, суралцах эрх авна.

5.3. Хэрэв энэхүү журмын 5.4-т заасны дагуу бүртгүүлээгүй бол элсэн суралцах эрхээсээ татгалзсан гэж үзэж тус журмын 4.4-д заасан шаардлагыг биелүүлсэн дараагийн хүнд эрхийг шилжүүлнэ.



ЗУРГАА. Багц цаг дүйцүүлэх

6.1. Элсэн суралцагчийн өмнө үзсэн мэргэжлийн хичээлийн багц цаг дүйцүүлэлтийг бүрэлдэхүүн/салбар сургуулийн мэргэжлийн тэнхим, ерөнхий суурь хичээлийн багц цаг дүйцүүлэлтийг Хөтөлбөр, чанарын баталгаажуулалтын хэлтэс, Элсэлт, бүртгэлийн хэлтэс хийж, элсүүлэн суралцуулахыг МУИС-ийн захирлын тушаалаар баталгаажуулна (хүснэгт 1).

6.2. Элсэгчийн өмнө судалсан хичээлүүдийн багц цагаас 60 хүртэл багц цагийг шилжүүлэн тооцож болно.

6.3. Багц цаг дүйцүүлэлттэй холбоотой асуудлыг МУИС-ийн “Сургалтын журам”, “Монгол улсын их сургуульд суралцагч шилжүүлэн суралцуулах журам”-аар зохицуулна.


6.4. Дүйцүүлсэн хичээлийг сургалтын мэдээллийн системд тухайн хичээлийн жилийн шилжиж ирсэн улиралд нэг л удаа оноож CR үнэлгээгээр оруулна.

ДОЛОО. Бусад

7.1. Элсэн суралцагч нь цаашид МУИС-ийн хөтөлбөр хооронд шилжих боломжгүй.

7.2. Элсэлттэй холбоотой бичиг баримтыг хуурамчаар үйлдсэн нь тогтоогдвол МУИС-д элсүүлэн суралцуулахгүй, элссэний дараа энэ зөрчил илэрвэл сургуулиас хасна.

* * *



МУИС-д Технологийн коллежээс элсэн суралцагчийн багц цаг тооцож, дүнг дүйцүүлсэн маягт

Элсэн суралцагчийн эцэг/эх/-ийн нэр _____ нэр _____ иргэний бүртгэлийн дугаар _____
 Суралцаж байсан улс: _____ техникийн коллежийн нэр: _____

Бүрэлдэхүүн сургууль, тэнхим: _____ суралцах хөтөлбөр _____ хөтөлбөр _____ батлагдсан он: _____
 Элсэж буй тэнхим: _____

| № | Элсэж буй хөтөлбөр дэх дүйцэх хичээлийн | | Дүн | | Өмнөх хөтөлбөрт судалсан судалсан хичээлийн | Дүн | | Дүнг дүйцүүлсэн багшийн/мэргэжилтний | | Огноо |
|--------------------------|---|--------|----------|-------|---|------|-------|--------------------------------------|------------|-------|
| | Нэр | индекс | Багц цаг | Огноо | | Тоон | Үсгэн | Нэр | Гарын үсэг | |
| Ерөнхий суурь хичээл | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | |
| Мэргэжлийн хичээл | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | |
| Нийт дүйцүүлсэн багц цаг | | | | | | | | | | |

Хянасан: _____ Тэнхимийн эрхлэгч: _____ / _____ / _____ огноо _____

Хүлээн авсан: Дүн бүртгэл хариуцсан мэргэжилтэн: _____ / _____ / _____ огноо _____

* Санамж: Суралцагч элсүүлэн суралцуулахдаа журмын багц цаг дүйцүүлэхтэй холбоотой заалтыг баримтална.